

## ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2012-2014 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ УДИРДАМЖ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9.1.1-д Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг хуульчлан батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2012 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хуульчлан баталсан.

Хууль батлагдсантай холбогдуулан түүнд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2012 оны төсвийн хязгаарын төслийг боловсруулсан. Төсвийн хязгаар нь суурь түвшинд үндэслэсэн<sup>1</sup>, өөрөөр хэлбэл бодлогын өөрчлөлтгүй гэж тооцсон дүн бөгөөд суурь төсөв ба төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан нийт зарлагын хязгаарын зөрүү нь бодлогын нөөц болох юм. Бодлогын нөөцийг 2012 оны төсөв боловсруулах хэлэлцүүлгийн явцад хуваарилна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2012 оны төсвийн хязгаар Засгийн газраар батлагдаагүй боловч цаг хугацааны давчуу байдлаас шалтгаалан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2012-2014 оны дунд хугацааны хөтөлбөрт суурилсан төсвийн төсөл бэлтгэх удирдамжийг үүгээр хүргүүлж байна (Төсвийн төсөл бэлтгэх холбогдох хавсралтуудыг <http://www.mof.gov.mn> болон <http://www.iltod.gov.mn> вэб хаягаар хандан электрон хэлбэрээр авч болно).

Энэхүү удирдамж нь ТЭЗ нарын 2012-2014 оны төсвийн төслийг бэлтгэх үндсэн зааварчилгаа болох бөгөөд дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

1. Төсөв, санхүүгийн суурь үзүүлэлтүүд
2. Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх зарчим, хуваарь
3. Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага
  - a. Ерөнхий шаардлага
  - b. Урсгал зардал
  - c. Хөрөнгийн зардал
  - d. Төсвийн орлого
4. Төсвийн төсөл бэлтгэх маягтууд, тэдгээрийн зааварчилгаа

### 1. Төсөв, санхүүгийн суурь үзүүлэлтүүд

УИХ-ын 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар дунд хугацааны төсвийн хүрээний суурь үзүүлэлтүүдийг хуульчлан баталсан.

Төсвийн хүрээний мэдэгдлийн хавсралт

Эдийнзасгийн нүндсэн үзүүлэлтүүд		Төсөөлөл		
		2012 он	2013 он	2014 он
1.	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ, хувь	16.6	14.8	15.4
2.	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	9	8	8
3.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	4,176.1	4,601.2	4,823.6
	- ДНБ-д эзлэх хувь	29.8	27.5	24.0
4.	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	5,113.5	4,929.8	5,218.0

<sup>1</sup>УИХ-д өргөн барьсан Төсвийн тухай хуулийн төсөлд “4.1.6. “суурь түвшинд үндэслэсэн төсөв” гэж макро эдийн засгийн таамаглалд нийцүүлж, тухайн төсөв хэрэгжих жилд хууль тогтоомж, эсхүл төрийн бодлогод өөрчлөлт орохгүй байхаар тооцсон төсвийн тооцоог хэлнэ.” гэж томъёолсон.

	- ДНБ-д эзлэх хувь	36.5	29.4	26.0
5.	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ	25.2%	-3.6%	5.8%
	- ДНБ-д эзлэх хувь	7.3%	-1.1%	1.4%
6.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-937.4	-328.7	-394.4
	- ДНБ-д эзлэх хувь	-6.7%	-2.0%	-2.0%
7.	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,098.3	1,053.6	1,118.1
	- ДНБ-д эзлэх хувь	7.8	6.3	5.6
8.	Улсын өрийн нийт хэмжээ /тэрбумтөгрөг/	7,277.5	7,181.2	7,031.6
	- ДНБ-д эзлэх хувь	51.9	42.9	35.0
9.	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжих зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	218.8	218.8	218.8
	- ДНБ-д эзлэх хувь	1.8%	1.4%	1.1%

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тэнцвэржүүлсэн байдлаар тооцно гэж заасан. Үүний дагуу холбогдох эрдэс баялгийн үнийн таамаглалыг боловсруулж 2012 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг дунджаар 6,443.0 ам.доллар, тэнцвэржүүлсэн боловсруулсан нүүрсний үнийг 151.1 ам.доллар, төгрөгийн нэг ам.доллартай харьцах ханшийг 1,164.6 тус тус байхаар төсвийн хүрээний мэдэгдэлд тооцсон.

## 2. Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх зарчим, хуваарь

### **2.1. Төсвийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэхэд баримтлах зарчим**

1. Зарлагын хязгаар гэдэг нь зөвхөн суурь түвшинд үндэслэсэн төсөв юм. Энэ нь өмнөх жилүүдийн зарлагын хязгаарын томъёоллоос ялгаатай бөгөөд бодлогын өөрчлөлтгүй гэж тооцон хийсэн дүн болно. Иймд нийт төсөв нь төсвийн хязгаар буюу суурь төсвийн дүн дээр бодлогын нөөцийн дүнг нэмж авсантай тэнцэх учиртай. Бодлогын нөөцийг төрийн бодлогод өөрчлөлт орох, шинээр төсөл, хөтөлбөр, арга хэмжээ санхүүжүүлэхэд ашиглана. Бодлогын нөөцийг 2012 оны төсөв боловсруулах явцад хуваарилна.
2. Бодлогын нөөц нь нэгдсэн төсвийн хүрээнд буюу улсын төсөв, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв болон Хүний хөгжил сангийн төсөвт ашиглах боломжтой нийт дүн юм. 2012 онд бодлогын нөөцийг дараах байдлаар тооцсон болно:
  - a. Хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхэд 247.5 тэрбум төгрөг (үүнд улсын нөөц бүрдүүлэх, материаллаг бус зэрэг бусад хөрөнгийн зардал орно, мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт орж болно);
  - b. Төсвийн тухай хууль батлагдсан тохиолдолд орон нутгийн төсвийн харилцааг зохицуулахад зориулан 200.0 тэрбум төгрөг;

с. Шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний урсгал зардлыг санхүүжүүлэхэд 400.0 тэрбум төгрөг.

3. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын суурь түвшинд үндэслэсэн зарлагын хязгаарын дүнг бодлогын тэргүүлэх чиглэл, эх үүсвэрийн нөөц боломжтой уялдуулан Сангийн яам бууруулж болно.
4. *Хөтөлбөр* гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэгдсэн багц арга хэмжээг хэлнэ. *Арга хэмжээ* гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг хэлнэ. Хөтөлбөр, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч нар хэт ерөнхий буюу хэт нарийвчилсан хэлбэрээр тодорхойлохоос зайлсхийх хэрэгтэй.

## **2.2. Хэлэлцүүлэх хуваарь**

Дор дурдсан хугацаанд төсвийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн байна. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийн саналаа 8 дугаар сарын 15-ны дотор Сангийн яаманд ирүүлнэ (Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг хавсралтад заасан хуваарийн дагуу хүлээн авна).
2. Сангийн яам 8 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 5-ны хооронд төсвийн ерөнхийлөн захирагч нартай төсвийн хэлэлцүүлгийг хийн, төсвийн төслийг хянаж дуусна.
3. Сангийн яам төсвийн төсөлд инфляцийн болон бусад бодлогын тохируулгыг 9 дүгээр сарын 5-наас 9 дүгээр сарын 15-ны хооронд хийж дуусна.
4. Сангийн яам 9 дүгээр сарын 15-наас 30-ны хооронд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

## **3. Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага**

### **3.2. Ерөнхий шаардлага**

1. Төсвийн төслийг загвар маягтуудын дагуу шинэчилсэн эдийн засгийн ангиллаар боловсруулна. Шинэчилсэн эдийн засгийн ангиллын талаарх заавар, тайлбарыг <http://www.iltod.gov.mn/> хаягаас авна уу;
2. Аливаа нэг зардал нь ямар нэг хөтөлбөр, арга хэмжээнд хамаарсан, тодорхой зориулалттай байх;
3. Бүх хөтөлбөр, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлж, энэхүү удирдамжинд тусгагдсан хавсралтуудын дагуу тодорхой бичиж ирүүлнэ. Сангийн яам дараах зүйлсийг харгалзан төсвийг боловсруулах болно:
  - a. Бодлогын ач холбогдол (төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлэх мэдээлэл нь маягтын дагуу боловсруулж, эрэмбэлсэн байх нь төсөвт тусгагдах нэгэн үндэслэл болно);
  - b. Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдал (төсөв боловсруулах явцад зөвхөн хавсралтаар хүргүүлэх маягтын дагуу боловсруулсан тооцоог харгалзаж үзэх болно).
4. Төвлөрсөн арга хэмжээ гэх мэт эдийн засгийн зориулалт нь тодорхойгүй ангиллаар зардал төлөвлөхгүй байх;

5. Төсвийн төслийн саналыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа төсвийн норм, нормативын эрх зүйн актын хамт ирүүлнэ (өмнө нь төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн боловч шаардлага хангахгүй байгааг анхаарах);
6. Төсвийн төслийн саналыг албан бичиг болон электрон хэлбэрээр ирүүлнэ.

### **3.3. Урсгал зардал:**

Төсвийн төсөлд тусгагдах урсгал зардлын хувьд дараах зарчмын дагуу боловсруулна. Үүнд:

1. Хөтөлбөр, арга хэмжээний ангиллыг төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тодорхойлон ирүүлнэ. Ангиллыг төсвийн төслийг ирүүлэхээс өмнө Сангийн яамны салбар хариуцсан ажилтнуудтай урьдчилан тохиролцохыг зөвлөж байна. Ингэснээр төсөв боловсруулсны дараа хөтөлбөр, арга хэмжээний ангилалд дахин өөрчлөлт оруулах явдлаас зайлсхийх боломж бүрдэх юм.
2. Төсвийн ерөнхийлөн захирагч нар энд хавсаргасан тусгай маягтын дагуу хязгаараас хэтрэх зардлын тайлбар, тооцоог боловсруулан ирүүлнэ. Шинээр батлагдан гарсан хууль, журам, тогтоолуудыг төсвийн саналдаа хавсаргасан байна. Бодлогын өөрчлөлтийн хүснэгтийг бэлтгэхдээ хөтөлбөрийн өөрчлөлтийн төлөвлөгөөг хамтад нь бэлтгэсэн байх шаардлагатай. Хөтөлбөрийн өөрчлөлтөд эдийн засгийн ерөнхий төлөв байдал болон хүн амын хүчин зүйлс, бодлогын өөрчлөлтөөс шалтгаалан зарлага нь өсөх, буурах, эсхүл хөтөлбөр арга хэмжээ дуусгавар болох тухай үндэслэл, тайлбар, нотолгоог бэлтгэж ирүүлнэ.
3. Төсвийн ерөнхийлөн захирагч нар жилийн төсвийг хэрэгжүүлэх явцад зардлын эдийн засгийн ангиллын зүйл хооронд зохицуулалт хийх тухай хүсэлт ихээр ирүүлж байгаа нь зардлын төлөвлөлтийг бодитой хийх шаардлагатайг харуулж байна. 2012 оны төсвийн жилээс эхлэн Төсвийн хуваарийг боловсруулах, өөрчлөлт оруулах журмыг батлуулан мөрдүүлж, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах асуудлыг хязгаарлах чиглэл байгаа тул зардлын зүйлсийг бодитой төлөвлөхийг анхааруулж байна.
4. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн тооцоололд эрчим хүч, цэвэр бохир усны үнэ тарифыг 2011 оны түвшинд, цалин, тэтгэвэр тэтгэмжийн өсөлтийг тэгтэй тэнцүү байхаар тооцсон байна. Үүнийг 2012 оны төсөв болон 2013-2014 оны төсвийн тооцоонд мөрдөнө. Тогтмол зардлын үнийн өсөлтийг эдийн засгийн ангиллын аль хэсэг дээр хэрэглэхийг Сангийн яам тогтооно.
5. Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн багцын байгууллагуудад хязгаар тогтоон өгч болно.
6. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэхтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцыг тус тусад нь хэвлэх тул хөтөлбөрт төсвийн танилцуулгыг үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хүрэх үр дүнтэй уялдуулан дэлгэрэнгүй хийж ирүүлнэ.
7. Төсвийн ерөнхийлөн захирагч нар шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, түүнд багтах арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна. Ач холбогдол илүү өгч байгаа хөтөлбөр арга хэмжээнээс эхлэн ач холбогдол багатай хөтөлбөр арга хэмжээг жагсаах ба хэрэв шаардлагатай бол хөтөлбөрийн өөрчлөлтийн улмаас нэмэлт санхүүжилт шаардлагатай хөтөлбөр арга хэмжээний эх үүсвэрийг эрэмблэгдсэн хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтад үндэслэн зохицуулалт хийх болно.
8. Холбогдох шийдвэрийн дагуу бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт орсон бол төсвийн төсөлдөө тодорхой зааж тусгана.

9. Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн урсгал зардлыг тодорхойлсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагууд өөрсдийн 2012-2014 оны төсвийн төслийн саналаа боловсруулан ирүүлэхдээ:

- 1) Энэхүү удирдамжид заасан зааварчилгааг баримтлан,
- 2) Хөтөлбөрөөр төлөвлөн,
- 3) Хавсралтын дагуу төсвөө боловсруулан,
- 4) Төсвийн зарлагын хязгаарт суурилсан байна.

### **3.4. Хөрөнгийн зардал**

Хөрөнгийн зардлын төлөвлөлтийг хийхдээ дараах шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг тусгана. Үүнд:

1. **Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг ач холбогдлоор нь эрэмбэлсэн байх;**
2. Хайгуул, зураг төсөв, техник-эдийн засгийн үндэслэл, газрын зөвшөөрөл нь бэлэн болж эрх бүхий байгууллагаар баталгаажсан байх;
3. Олон улсын байгууллага, хандивлагч оронтой хийсэн хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцэл нь батлагдаж тухайн жилд шаардагдах санхүүжилтийн гадаад болон дотоод эх үүсвэр нь шийдвэрлэгдсэн байх;
4. Шинээр эхлүүлэх хөрөнгө оруулалтын барилга, байгууламжийг ашиглалтанд оруулсны дараа гарах урсгал зардлын тооцоог 2 жилээр гарган ирүүлсэн байх (маягт-8).

### **3.5. Төсвийн орлого**

Монгол Улсын төсвийн орлогын бодлого нь 2012 онд төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлэх, татвар хураалтыг эрчимжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд төсвөөс санхүүжигдэх ажиллагааг хэвийн явуулах эх үүсвэрийг бүрдүүлэхэд чиглэгдэх бөгөөд орлогын төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Уул уурхайгаас бусад салбарын хувьд төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл, ДНБ, эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийн өсөлттэй уялдуулан 2012 оны төслийг өмнөх жилийн төлөвлөгөөнөөс бууруулахгүй байхаар тооцох;
2. Нийт импорт, үүнээс татвартай импорт, онцгой татвартай барааны импортын тоо хэмжээ үнэлгээг олон жилийн дундаж, өмнөх жилүүдийн өсөлтийн түвшин, хүлээгдэж буй гүйцэтгэл болон эдийн засгийн суурь үзүүлэлтүүдэд үндэслэн дэлгэрэнгүй судалгааг гарган оновчтой тооцож гаалийн татвар хураалтыг эрчимжүүлэх, нөөц бололцоог бүрэн дайчлах;
3. Олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас зарласан ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн таамаглал болон уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөнд үндэслэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, холбогдох бусад татварын орлогыг бодитой тооцож, төсөвт төвлөрүүлэх;
4. Төрийн өмчит компанийн хувьд зардлын тооцоог шахуу хийх, энэ талаар холбогдох албан тушаалтан, Төрийн өмчийн хороо бусад байгууллагатай санал солилцох, хамтарч ажиллах;

5. Оюу толгой, Таван толгой төслөөс төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг тооцохдоо төслийн гэрээний онцлог шинжүүдийг авч үзэх, хөрөнгө оруулалттай холбоотойгоор төсөвт орох нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад татварын тооцоог нарийвчлан хийж тусгах.

#### 4. Төсвийн төсөл бэлтгэх маягтууд, тэдгээрийн зааварчилгаа

---

- 1-3 дугаар маягт нь төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт багцын хувьд мэдээлэл оруулах зориулалттай.

**Маягт 1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналын товчоо.** Энэхүү маягт нь ерөнхий мэдээллийг агуулсан байна.

- Энэ хэсэгт төсвийн ерөнхийлөн захирагчийннэр, код, төсвийн багцын ХБГ, зарлагын хязгаар, эдгээрийн зөрүүний тухай үндсэн мэдээллийг оруулна. Түүнчлэн энэ хэсэгт салбарын нийт орон тоог төрийн албан хаагчийн ангиллын дагуу оруулж өгсөн байх шаардлагатай. Энэ хэсэгт тодорхойлсон зарим үндсэн мэдээлэл бусад маягтын эхэн хэсэгт нэгэн адил давтагдана.

**Маягт 2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Хөтөлбөрийн мэдэгдэл.** Энэ хэсэгт одоо хэрэгжиж байгаа хөтөлбөрийн талаарх мэдээллийг хөтөлбөр бүрээр харуулна. Хөтөлбөрийн тодорхойлолт хэсэгт тухайн хөтөлбөрийн хамрах хүрээ, бүрэлдэхүүн, зориулалтыг товч тодорхойлсон байна. Хэрэв одоо хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээнд (голдуу тоон үзүүлэлт) өөрчлөлт орсон бол энэ маягтад тусган тайлбарлана.

**Маягт 3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт.** Энэ маягтаар төсвийн хөрөнгөөр хөтөлбөрийн зорилтыг хэрхэн хангах тухай амлалтыг урьдчилан тооцож харуулна. Хүрэх үр дүнг тодорхойлохдоо хэт ерөнхий, бүрхэг байдлаар тодорхойлохоос зайлсхийж, хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, бодитой, хугацаатай үзүүлэлтийг тодорхойлно. Жишээ нь, Ерөнхий боловсрол хөтөлбөр дэх сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жинг 58 хувьд хүргэнэ гэх мэт. Тухайн хөтөлбөрийн хамрах цар хүрээ, онцлогоос хамаарч гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хөтөлбөрийн түвшинд ерөнхий эсхүл бүтээгдэхүүн арга хэмжээ, төсөл бүрээр нарийвчлан тодорхойлж болох ба эдгээр нь хөтөлбөрийн зорилгыг хангах ахиц дэвшлийг хэмжихэд хэрэглэх боломжтой тоон утгаар илэрхийлэгдсэн байна. Жишээ нь: цэцэрлэгт хамрагдах хүүхдийн дундаж тоо г.м.

- 4-7 дугаар маягтуудыг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл нь тухайн багцын хязгаараас<sup>2</sup> буюу суурь түвшнээс хэтэрч шинээр хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх, тэдгээрт өөрчлөлт оруулах тохиолдолд холбогдох тооцоо, мэдээллийг оруулж ашиглана.

**Маягт 4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлогын саналын тооцоолол, тайлбар.** Төсвийн байгууллагын өөрийн орлогыг тооцохдоо төсвийн ерөнхийлөн захирагч нар тухайн байгууллагын урьд оны дүнд суурилан, зөрүүг тайлбарлах хэлбэрээр 4 дүгээр маягтын дагуу боловсруулан, санал болгож буй төсөлд тусгана.

---

<sup>2</sup>Суурь түвшинд үндэслэсэн төсөв

**Маягт 5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн суурь түвшинд үндэслэсэн төсвийн урсгал зарлагын саналын тооцоолол, тайлбар.** Урсгал төсвийн хязгаар нь суурь түвшинд үндэслэсэн төсөв буюу бодлогын арга хэмжээнд өөрчлөлт орохгүй байхаар тооцсон дүн болно. Урсгал төсвийн тооцооллыг 5 дугаар маягтын дагуу боловсруулан, санал болгож буй төсөлд тусгана.

**Маягт 6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгийн зардлын саналын тооцоолол, тайлбар.** Хөрөнгийн зардлын санал нь суурь түвшинд үндэслэсэн болон шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас бүрдэнэ. Хөрөнгийн зардлын саналыг 6 дугаар маягтын дагуу боловсруулан, санал болгож буй төсөлд тусгана. Суурь түвшинд үндэслэсэн хөрөнгийн зардлын нөлөөлөгч хүчин зүйлсийн задаргаанаас гадна шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эрэмбэлсэн жагсаалтыг 6 дугаар маягтын дагуу боловсруулна.

**Маягт 7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эргэж төлөгдөх цэвэр зээлийн саналын тооцоолол, тайлбар.** Төсвийн стандартын дагуу Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний зээл буюу дамжуулан зээл олголт, түүний авлага барагдуулалт нь Эргэж төлөгдөх цэвэр зээл гэсэн хэсэгт бүртгэгдэн нийт зарлагын дүнд тооцогдох ёстой. Авлага барагдуулалт нь зарлага талд хасах дүнгээр тусч, зарлагыг бууруулах гүйлгээ болно. Мөн аж ахуйн нэгж, корпорацийн хувьцаа худалдан авах, дүрмийн сан бүрдүүлэх гүйлгээ нь энд бүртгэгдэнэ. Эргэж төлөгдөх цэвэр зээлийн саналыг 7 дугаар маягтын дагуу боловсруулан, санал болгож буй төсөлд тусгана. Мөн шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эрэмбэлсэн жагсаалтыг боловсруулна.

- 8 дугаар маягтыг шинээр ашиглалтад орох хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөртэй холбоотой урсгал зардлын тооцоог оруулахад ашиглана.

**Маягт 8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын урсгал зардлын саналын тооцоолол, тайлбар.** Шинээр эхлүүлэх хөрөнгө оруулалтын барилга, байгууламж тус бүрийн бүтээн байгуулалт дуусаж, ашиглалтанд оруулсны дараа гарах урсгал зардлын тооцоог 2 жилээр гарган боловсруулан, санал болгож буй төсөлд тусгана.

САНГИЙН ЯАМ